

## Аймгийн засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн ХШҮ-ний тайлан

## Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар

2023 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1	1.1. "Ковид-19" халдварт цар тахлын үед иргэн аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1.1.1.1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулж, ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2023		14	"Ковид-19" халдварт цар тахлын дэгдэдлтгийн үед хэрэгжилтийг ханган, 2020-2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнасан. Эрүүл мэндийн Сайдын тушаалын дагуу хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас хувиараа бизнес эрхлэгч, иргэн аж ахуй нэгжүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр 2 удаа, ариун цэвэр халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл сургалтыг 1 удаа зохион байгуулан Улиастай болон бусад сумдын хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагууд ээлжит халдваргүйтгэлээ хийлгэсэн байна.	90%

2		1.1.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулж, хяналт тавьж ажиллана.	2021 - 2023		200	<p>Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг нийт 1330 объектын 237124 м.кв, нийтийн эзэмшлийн 370142 м.кв талбайд Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээр, голомтын халдваргүйтгэлийг Коронавируст халдварын батлагдсан 11712 тохиолдлын зам мөрийн зураглалын дагуу 1053 байгууллага, аж ахуйн нэгж, 2249 айл өрхийн 566800 м.кв талбайд ЗӨСТ, сумын Эрүүл мэндийн төвүүд шүрших, мананцаржуулах, арчих аргаар, хатуу хучилттай зам талбай, нийтийн эзэмшил орон сууцны хонгил, тоглоомын талбайд 925142 м.кв талбайд МЭГ, Ариусгал Завхан, Монклин ХХК, ЗӨСТ-өөр Жавелионы 0,06% уусмал, суперкиллын уусмалаар шүрших, мананцаржуулах аргаар эцсийн халдваргүйтгэл хийлгэн хамтран ажилласан байна.</p>	100%
---	--	--	-------------	--	-----	---	------

3	1.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ	1.2.1.2. Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлнэ	2021 - 2023		15	2022 онд харьяа эрүүл мэндийн 29 байгууллагад нийт 14.5 сая төгрөгийн өртөг бүхий хүнсний байнгын нөөц бүрдүүлэн, бэлэн байдлыг ханган ажилласан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд 343.350.000 /гурван зуун дөчин гурван сая гурван зуун тавин мянган/ төгрөг, Аймгийн 2023 онд хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан 2 ажил үйлчилгээг гүйцэтгэхэд 80 сая төгрөг тус тус батлуулсан байна. 24 сумд 2023 онд гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын хэрэгжилтийг хангуулахаар тусгагдсан санхүүжилт Засаг даргын нөөц санд 120 сая төгрөг төсөвлөн батлуулсан байна. 2022 онд харьяа эрүүл мэндийн 29 байгууллагад нийт 14.5 сая төгрөгийн	90%
---	---	---	-------------	--	----	---	-----

4	1.2.1.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна	2021 - 2023		200	Улаанбурхан өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, бага насны 10 сараас 8 нас хүртэлх хүүхдийг улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах 9473 хүүхдийн судалгааг гаргасан. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 7200 хүн/тун вакцин татан авч дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан 4972 хүн/тун вакцин хийж хамрагдалт 69 хувьтай байна. Дархлаажуулалтын үйл ажиллагаа эхлүүлэх нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан харьяа эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл өгч ажиллаж байна. Улаанбурхан, Салхинцэцэг, Улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр сэрэмжлүүлэг зөвлөмжийг харьяа эрүүл мэндийн байгууллага, Боловсрол	90%
---	--	-------------	--	-----	--	-----

5		1.2.1.4. Шинэ коронавирусний халдварыг тодорхойлох оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлнэ	2021 - 2023		10	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. Гамшгийн үеийн бэлэн байдлын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 38 нэр төрлийн 106,0 сая төгрөг, Одоо эрүүл мэндийн газрын нөөцөд 8 нэр төрлийн 90 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцтэй байна. Эрүүл мэндийн байгууллагууд 8 нэр төрлийн 8.1 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцтэй байна. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх команд штабын сургуулалтыг зохион байгуулахад идэвхитэй оролцон гамшгаас хамгаалах хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2 удаа тодотгол хийсэн. Хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүч хэрэгсэлийн нөөцийн бэлэн байдлын судалгааг гарган ажилласан. Дайчилгаа зохион байгуулахад 2 бол 20	90%
6		1.2.1.5. Аймгийн нэгдсэн эмнэлэг, зарим “А” зэрэглэлийн эмнэлэг, оношилгоо эмчилгээний төвүүдийг РТ-ПСР төхөөрөмжөөр хангана	2021 - 2023		1	2023 оны хагас жилийн байдлаар ПГУ шинжилгээ хийгдээгүй байна. Түргэвчилсэн оношлогоог нийт 325 иргэнд хийснээс flu A-128, flu B-14, adenovirus- 41, RSV-87, SARS cov-1, N.pneumoni-1 оношлогдсон байна. ХӨСҮТ-ийн молекул биологийн лабораторид томуугийн 30 сорьц илгээсэн байна.	70%
7		1.2.1.6. Цар тахлын голомтод ажиллаж буй алба хаагчдыг эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулна.	2021 - 2023		6	“Ковид-19”-ын 16 тохиолдол бүртгэгдэж, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн хяналтад гэрээр эмчилсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100%
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							

8	2.1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	2.1.1.1. Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, нялхсын эндэгдлийг бууруулна.	2021 - 2024		эх/э-0, нялхас-14.5	2023 оны эхний 5 сарын байдлаар 505 эх төрсөн нь өмнөх оноос 116 төрөлт буюу 22,9 хувиар өссөн байна. Төрсөн эхчүүдийн 85,5 хувь нь 6 ба түүнээс дээш удаа хяналтын үзлэгт хамрагдсан байна. Нийт төрөлтийн дотор гэрийн төрөлтийн тохиолдол байхгүй байна. Аймгийн хэмжээнд 506 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 113 хүүхдээр өссөн байна. Амьд төрсөн хүүхдийн 45,2 хувь нь эрэгтэй хүүхэд, 54,8 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нийт төрсөн хүүхдийн 3,7 хувь нь 2500 гр-аас доош жинтэй, 4 тохиолдол буюу 0,7 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн байна. Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/ 3,9 байна. Эхний 5 сард 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 18572 хүүхэд хамрагдсанаас тураалтай 7, туранхай 20, өсөлтийн хямралтай 12	70%
---	--	--	-------------	--	---------------------	--	-----

9	2.1.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	2021 - 2024		8	<p>Эрүүл мэндийн үйлчилгээг бүрэн цахимжуулж дотоод сүлжээг өргөжүүлэн E-Health эрүүл мэндийн салбарын нэгдсэн программтай болсон. Аймгийн Нэгдсэн эмнэлэг шинжилгээний хариуг холбогдох эмч нарт шууд хүргэж, иргэд цахим үйлчилгээний нэг цонхноос авдаг болсон. E-Mongolia системээр дамжуулан 609 иргэн онлайнаар цаг авсан байна. E-Mongolia цахим платформд эрүүл мэндийн чиглэлээр 14 үйлчилгээг нэвтрүүлж иргэдэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2023 оноос лавлагаа шатлалын эмнэлэгт өвчтөн илгээх 13А маягийг цахимаар илгээдэг болсон 5 сарын байдлаар 87 өвчтөнийг илгээсэн байна. Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн серверийг шинэчлэхээр төлөвлөж, тендерт Монотик ХХК нь шалгарч, 33,0 сая төгрөгийн өртөг бүхий</p>	90%
---	--	-------------	--	---	--	-----

10	2.1.1.3. Сумдад явуулын амбулаторийн цогц үйлчилгээг хүргэнэ	2021 - 2024		21000	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд харьяаллын багийн иргэдэдээ явуулын үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтыг зохион байгуулж 8157 иргэнд хүрч үйлчилсэн. 2023 оны 5 сарын байдлаар аймгийн хэмжээнд явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээг давхардсан тоогоор 9411 иргэнд хүргэсэн байна. 2023 оны 03 сарын 4-ны өдрөөс 2023 оны 4 сарын 30-ны өдрүүдэд 24 сумын отор нүүдлээр яваа малчин 433 өрхийн 782 иргэнд зөөврийн ЭХО, мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглан явуулын тусламж, үйлчилгээг хүргэсэн. Үүнээс: Жирэмсэн эх 67, 0-5 хүртэлх насны хүүхэд 68, ахмад настан 128, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 16, архаг суурь өвчтэй иргэн 177 байна. Өвчлөлийн бүтцээр нь авч үзвэл цусны даралт ихсэх өвчин, хоол боловсруулах замын эмгэг, бөөр шээсний замын</p>	70%
----	--	-------------	--	-------	---	-----

2.1.1.4. Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг өргөжүүлнэ	2021 - 2024		6500	Уламжлалт анагаах ухааны төв, Үе залгамжлагч сувилал, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт сэргээн засахын тасаг нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг амбулатори, өдрийн эмчилгээ, хэвтэн эмчлүүлэх чиглэлээр хүргэн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар ашигласан ор хоног 4848, дундаж ор хоног 34.5, орны фонд ашиглалт 138.5, орны эргэлт 20.5 байна. Шинээр чихний төөнө, гал эмчилгээ, халуун чулуун эмчилгээ, цес угаах эмчилгээг нэвтрүүлсэн. “Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг Улиастай суманд зохион байгуулж, үйл ажиллагаанд 130 иргэн хамрагдаж, үзлэг оношилгоо хийгдэж, сургалтын материал гарын авлагыг түгээсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт, сэргээн засах тасагт аймгийн 20005 дарагч	90%
---	-------------	--	------	--	-----

12

2.1.1.5. Зүрх судасны тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ	2021 - 2024		18.5	Зүрх судасны шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн амд 7,1, зүрхний шигдээсийн шалтгаант нас баралт 10000 хүн амд 0,67 байна. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 47548 иргэн хамрагдахаас 6100 иргэн хамрагдаж 12,8 хувийн хамралттай байна. Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлэгт 29193 иргэн хамрагдахаас 4981 иргэн хамрагдаж хамралт 17,1 хувьтай байна. Зүрх судасны кабинет нь зүрхний ачаалалтай сорилыг хийж эхний 20 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 5 хүнийг ангиографийн шинжилгээнд явуулж стент тавиулсан. 2023 онд зүрхний төрөлхийн гажигтай 21 тохиолдлыг илрүүлснээс 10 хүн хагалгаанд орж эмчлэгдсэн. Олдмол гажиг 2 тохиолдлыг оношлогдож хавхлага солиулах хагалгаанд орсон. Улиастай, Их-Уул сумдын 9 дүгээр ангийн 750 хүүхдэд зүрхний гажиг, шигдээсийн	70%
--	-------------	--	------	--	-----



15	2.1.1.8. Улиастай, Тосонцэнгэлийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тасаг, нэгжийг байгуулна	2021 - 2024		16	Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь "Яаралтай тусламж, Эрчимт эмчилгээ гемодиализийн тусламж үйлчилгээний тасаг"-ийн зохион байгуулалтыг шинэчлэн, "Яаралтай тусламжийн тасаг"-ийг бие даан байгуулж үйл ажиллагаа явуулж байна. Тасгийн засвар, тохижилт үйлчилгээнд аймгийн Засаг даргын нөөц сангаас 15 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2023 оны 5 дугаар сарын байдлаар яаралтай тусламжийн тасгаар нийт 1500 гаруй иргэн үйлчлүүлсэн байна. 2023 оны 3 сард урологийн кабинет байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 201 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс давсагны дуран 12, боолт 57 байна.	100%
----	--	-------------	--	----	---	------

2.1.1.9. Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024		30	2023 оны хагас жилийн байдлаар: ЭМЯ, Японы Хүүхдийг ивээх сан, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн хамтарсан хөрөнгө оруулалтаар эмнэлгийн багаж, хэрэгслийг нийлүүлсэн. ( хүчил төрөгчийн баллон, дагалдах хэрэгслийн хамт 24,5 сая төг, спирометр дагалдах хэрэгслийн хамт 177,4 сая төг, пульсоксиметр 60ш 6,7 сая төг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт ЭХО аппарат 35,0 сая, унтуулгийн аппарат 78,5 сая хагалгааны хажуугийн гэрэл 18,0 сая, таазны гэрэл 20,0 сая), Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Нэгдсэн эмнэлгийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тасагт хими эмчилгээ хийгдэх ариун орчныг бүрдүүлэхэд зориулж 10 нэр төрлийн 5,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг, Эрэгтэйчүүдийн кабинетэд 12 нэр төрлийн 19,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангана.	70%
---	-------------	--	----	--	-----

2.1.1.10. Эрүүл мэндийн бодлого хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын зөвлөлийг байгуулж ажиллуулна.	2021 - 2024		1	Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/72 дугаар захирамжаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан аймгийн Засаг дарга ахлан ажиллаж байна. 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зөвлөлийн анхны хурлыг зохион байгуулж, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийн 2023 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлан 5 зорилтын хүрээнд 12 ажил төлөвлөн энэхүү ажлын хүрээнд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх технологийг нэвтрүүлэхээр 25.0 сая төгрөг, төрөх тасагт хагалгааны гэрлийг сайжруулан шинэчлэхээр 25.0 сая төгрөгийг тус тус ОНХС-нд тусгуулсан байна.	100%
--	-------------	--	---	--	------

18		2.1.1.11. Рашаан сувиллын үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024		10	<p>Отгонтэнгэр рашаан сувилал (зү/11/34) нь рашаан сувиллын тусламж үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/150 дугаар тушаалаар 5 жилээр сунгасан.</p> <p>Отгонтэнгэр рашаан сувилал нь чанартай эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, рашаан сувиллын дэд бүтцийг хөгжүүлэх, ашиглалтын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн хөрөнгө оруулалт хийж сувиллыг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, сэргээн засварлах улмаар амарч сувилуулах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сувиллын газрын гал тогоо, амрагчдын 1-р байр, эмнэлгийн барилгын засварын ажлыг эхлүүлж, шавар эмчилгээний байрыг шинээр барих ажил хийгдэж байна.</p>	50%
----	--	--	-------------	--	----	--	-----

19	2.1.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.1.2.1. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний гаралтыг бууруулна.	2021 - 2024		7160	2023 оны хагас жилийн байдлаар 669 халдварт өвчин бүртгэгдсэнээс Ковид-19-ын тохиолдол 16 буюу 2,4%, бусад халдварт өвчин 97,6%-ийг эзлэж байна. Үүнээс: Салхинцэцэг 299 /44.7 хувь/, заг хүйтэн 146 /21.8 хувь/, арьс мөөгөнцөртөх 98 /14.6 хувь/, тэмбүү 77 /11.5 хувь/ байна. 18-с дээш насны 47311 иргэнээс сүрьеэгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан 231 иргэн хамрагдаж хамралт 0,48%-тай, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 504 хүн хамруулсан байна. Нийт сүрьеэгийн үзлэгээс шинэ 3, давтан 2 тохиолдол бүртгэгдэн эмчлэгдэж байна. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний хамралт: Артерийн гипертензи илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 47548 иргэнийг хамруулахаас хагас жилийн байдлаар 6100 /12.8 хувь/, үүнээс оношлогдсон 108 байна. Чихрийн шижин хэв шинж 2 илрүүлэг үзлэгт 20102 иргэнийг	70%
20		2.1.2.2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ	2021 - 2024		100	2022 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын гуравдугаар зэргийг 10, хоёрдугаар зэргийг 7, нэгдүгээр зэргийг 4 байгууллага хангаж нийтдээ 95 байгууллага байна. Эрүүл ажлын байрны болзолыг хангасан 5 байгууллага байна. Төсвийг жил бүр аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж 2021 онд 5.0, 2022 онд 8.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулж, 2023 онд "Чадварлаг эмч" арга хэмжээний хүрээнд 2.0 сая төгрөгийн төсвийг батлуулсан.	90%

21	2.1.2.3. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна	2021 - 2024		80%	Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт "Осол гэмтлээс сэргийлье", "Хорт хавдрын эсрэг тэмцэх дэлхийн өдөр", "Малчдын эрүүл мэндийг дэмжье", "Архидан согтуурахаас сэргийлье", "Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье", "Дэлхийн усны өдөр", "Давсны хэрэглээг бууруулах өдөр", "Сүрьеэтэй тэмцэх өдөр"-ийн хүрээнд 12.680 иргэнд сургалт хийсэн. (Цахим 252, танхим 12428) ЭМЯ, НЭМҮТ, СЭМҮТ, ХӨСҮТ, НҮБ-с боловсруулан гаргасан сурталчилгааны материалуудыг байгууллагын цахим хуудас болон 24 сумын фэйсбүүк группэд нийтэлсэн. Нийт 21 дүрс бичлэг, Бичвэр (зар, мэдээ, уриалга) 17, Мэргэжлийн эмчийн зөвлөмж 16, Мэйншин хийгдсэн 6, Зурагт хуудас 204 нийт 264 мэдээлэл оруулж 179017 хандалт авсан байна. Орон нутгийн АР1 төлөвлөгөө 8 төрлийн Хүлээгдэж байна	90%
22	2.1.2.4. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд тандалт судалгаа хийнэ	2021 - 2024		2	Хүлээгдэж байна	0%

2.1.2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг бэхжүүлнэ	2021 - 2024		2000	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. 2022 онд эм тарианы нөөц 14 нэр төрлийн 252 сая төгрөг, эмнэлгийн хэрэгсэл 40 нэр төрлийн 346.8 сая.төгрөг, 109 сая төгрөгийн оношлуурийн татан авалт хийгдсэн. Эм, урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 93 нэр төрлийн 6670.7 сая төгрөгийн вакцин, эм, эмнэлгийн хэрэгсэл, ХХХ, тоног төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангаар 24 нэр төрлийн 771.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сургалт үйл ажиллагаа, Хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 1259.5 сая төгрөгийн барилгын засвар, тоног төхөөрөмж, эм	90%
---	-------------	--	------	---	-----

2.1.2.6. "Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээ	2021 - 2024		100	<p>"Хөдөлгөөн Эрүүл мэнд" арга хэмжээний зорилтыг "Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээний зорилттой уялдуулан төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагааг төлөвлөсөн. Хэрэгжилт 50 хувьтай байна. "Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах" 2 сарын аяны удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Чадварлаг эмч" арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд ОНХС-аас 6.5 сая төгрөг санхүүжигдэхээр батлагдсан. Аяны хүрээнд 26 эрүүл мэндийн байгууллага, Улиастай сумын 60 гаруй аж ахуй нэгж албан байгууллагад "Хөдөлгөөн, эрүүл зөв зохистой хооллолт" сэдвээр сургалт хийж, БЖИ-ийг танита аппаратаар хэмжин иргэдийн биеийн жингийн эрсдэлийн үнэлгээг насны бүлгээр хариуцаж</p>	90%
--	-------------	--	-----	---	-----

2.1.2.7. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ	2021 - 2024		100	<p>"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний 8 зорилт 52 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт 70 хувьтай. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 669 халдварт өвчин бүртгэгдсэнээс ковид-19 тохиолдол 16 буюу 2,4%-ийг бусад халдварт өвчин 97,6%-ийг эзлэж байна. Үүнээс: салхинцэцэг 299 /44.7 хувь/, Заг хүйтэн 146 /21.8 хувь/, арьс мөөгөнцөртөх 98 /14.6 хувь/, Тэмбүү 77 /11.5 хувь/ байна. 18-с дээш насны 47311 иргэнээс сүрьеэгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан 231 иргэн хамрагдаж хамрагалт 0,48%-тай, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 504 хүн хамруулсан байна. Нийт сүрьеэгийн үзлэгээс шинэ 3, давтан 2 тохиолдол бүртгэгдэн эмчлэгдэж байна. Уушигны 5 тохиолдол илэрсэн байна. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг "ТИЙМ ЭЭ БИД СҮРЛЭЭГ ҮСТЭГЭЖ ЦАВНА"</p>	70%
--	-------------	--	-----	---	-----

2.1.2.8. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ	2021 - 2024		100	Аймгийн Засаг даргын 2023 оны 72 дугаар захирамжаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийг 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. "2023 оны ажлын төлөвлөгөөг хурлаар хэлэлцэн баталж 5 зорилтын хүрээнд 12 ажлыг төлөвлөсөн. Хэрэгжилтийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх технологийг нэвтрүүлэхээр 25.0 сая, төрөх тасагт хагалгааны гэрлийг сайжруулан шинэчлэхээр 25.0 сая нийт 50,0 сая төгрөгийн Орон нутгийн хөгжлийн сангаас гаргуулахаар аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 69 дүгээр тогтоолоор нэмэлтээр батлуулсан. 2023 оны 6 сарын байдлаар 0-17 насны 16368 хүүхэд буюу 62.3 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж 80 орчим хувьд нь шүд цоорох өвчин илэрч эмчлэгдсэн.	70%
--	-------------	--	-----	---	-----

2.1.2.9. "Хавдрын эсрэг" арга хэмжээ	2021 - 2024		100	Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагаа төлөвлөсөн. 2023 онд хавдрын хяналтад 720 иргэн, үүнээс шинээр 56 оношлогдож, хими эмчилгээнд 2 хүнийг хамрууллаа. Энэ онд ОНХС-ийн дэмжлэгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн хавдарын тасагт 5.0 сая төгрөгөөр 11 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан. 2023 оны 3, 4, 5 дугаар сарыг "Бүдүүн шулуун гэдэсний хавдрын эсрэг, Элэгний хавдрын, "Уушигны хорт хавдрын эсрэг" сар болгон зарлаж, хэрэгжилтийн хүрээнд бүдүүн шулуун гэдэсний хавдраас урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйл, үзлэг оношлогооны чиглэлээр сурталчилгааны 21 зурагт хуудас боловсруулан цахим орчинд түгээсэн байна. ЕБС-н 70 суралцагчид сургалт хийж, АХА тэмцээн зохион байрлал амжилттай	70%
--------------------------------------	-------------	--	-----	---	-----

2.1.2.10. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээ	2021 - 2024		100	<p>2023 онд Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт, 21 үйл ажиллагааг төлөвлөсөн. Гепатит В, С вирус оношлогдсон 45 иргэн үүнээс Гепатит В вирустай 35 иргэн, Гепатит С вирустай 10 иргэн байна. Энэ онд жирэмсэн В,С вирусын халдвар шинээр оношлогдсон 5, хяналтад байгаа В вирустай 15, С вирустай 4, В,Д хавсарсан халдвартай 1 байна. В вирустай эхээс төрсөн 23 нярайд иммуноглобулин хийгдсэн байна. Үүнээс дархлал тогцын шинжилгээнд хамрагдсан 6 байна. - JCI Монгол Төрийн бус байгууллагатай хамтран "АМЬДРАЛ БЭЛЭГ" төслийн хүрээнд Элэгний В, С, Д вирустай, элэгний цирроз, хавдар болон бусад эмгэг бүхий иргэдэд зориулсан "Сэтгэлийн хүчээр өвчнөө ялъя" сэдэвт сургалт зохион байгуулагдаж вируст халдварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч</p>	70%
---	-------------	--	-----	---	-----

2.1.2.11. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээ	2021 - 2024		100	Харшлаас сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөг 3 зорилт, 15 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Харшлын эсрэг дэлхийн 7 хоног, “Ургамлын тоосны харшилтай тэмцье” аяны хүрээнд “Харшил түүнээс сэргийлье, Хүнсний харшил үүсгэгч, Агаарын бохирдол, Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь, Эмийн зохистой хэрэглээ, эмийн харшил” зэрэг сэдвүүдээр сургалт мэдээллийг 2500 иргэнд хүргэж, 505 ширхэг гарын авлага тараан, эмэнд харшилсан иргэдийг “Эмийн гаж нөлөөний хуудас” -аар асуулга авч, дүгнэлт хийж ажиллалаа. Эрүүл мэндийн байгууллагууд “Эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн зөв зохистой хэрэглээ” сэдвээр дотоод сургалт хийж, байгууллагын фейж хуудсанд мэдээлэл	50%
--	-------------	--	-----	---	-----

30		2.1.2.12. “Эрүүл чийрэг эрхүн” арга хэмжээ	2021 - 2024		100	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д эрэгтэйчүүдийн кабинет байгуулан Орон нутгийн хөгжлийн сангаас 19,5 сая төгрөгөөр 12 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжөөр ханган үйл ажиллагаа тогтворжиж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 дүгээр тушаал “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж дурангийн хагалгаа 15, нээлттэй хагалгаа 14 хийсэн байна. Давсны зохистой хэрэглээ, өсвөр үеийн сэтгэлзүйн онцлог, үе тэнгийнхний дээрэлхэлт сэдвээр 1943 өсвөр үеийнхэнд сургалт мэдээлэл хийж, “Эрхээ, Тэгшээ” комик цуврал, “Үе тэнгийнхний дээрэлхэлт, дарамт” подкастыг хүргэн ажилласан байна. Эрүүл мэндийн газрын даргын А/66 дугаар тушаалаар “Жиндэрийн дэд</p>	100%
----	--	--	-------------	--	-----	---	------

31	2.1.3. Оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	2.1.3.2. Лавлагаа шатлалд хийгддэг оношилгоо, эмчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэвтрүүлнэ.	2021 - 2024		6	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн "дэмжих төв" нь эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо эмчилгээг тасралтгүй явуулж байна. 2023 оны хагас жилийн байдлаар 2284 хүнд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн. Үүнээс 44% эрэгтэй 56% эмэгтэйчүүд байна. Өвчлөлийг хувиар авч үзвэл ХБЭТЭ 35%, бамбай булчирхайн эмгэг 25%, БШЯЭТЭ 22%, түрүү булчирхайн эмгэг 8%, хөхний булчирхайн эмгэг 5%, эрүүл хүн 5%-тай байна. Хавдар төст үүсгэвэр 11 тохиолдол сэжиглэгдэж 3-р шатлалын эмнэлэгт илгээсэн. Бриллиант эмнэлэгтэй хамтран ажиллаж ходоодны эрт үеийн хавдар хуулах хагалгаа 2, улайн хоолойн өргөссөн судас боох ажилбар 13 -ийг хийж, аймгийн эмч нар улаан хоолой, бүдүүн гэдэсний ургацаг авах ажилбар 44 тохиолдолд хийлээ. 2чх	90%
----	---	--	-------------	--	---	--	-----

32		2.1.3.3. Мобайл технологийг өргөжүүлэн, үйл ажиллагааг эрчимжүүлнэ	2021 - 2024		25	<p>2023 оны 5 сарын байдлаар Мобайл технологийн тоног төхөөрөмж ашиглан 860 гаруй иргэнд амбулаторийн болон явуулын тусламж, үйлчилгээ хүргэн ажилласан байна. Үүнээс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад 38 иргэнийг онош тодруулахаар илгээж, мэргэжлийн тусламж, үйлчилгээ авч ажилласан. Улиастай сумын Дөрвөн-Оноо, Биндэргарав ерхийн эрүүл мэндийн төвүүдэд Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр Мобайл технологийн тоног төхөөрөмж нийлүүлэн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 6 СЭМТ, 2 ӨЭМТ, нийт 8 эрүүл мэндийн байгууллага Мобайл технологийн тоног төхөөрөмжийг тусламж, үйлчилгээндээ ашиглаж байна.</p>	90%
----	--	--	-------------	--	----	---	-----

33	2.1.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2.1.4.1. "Чадварлаг эмч" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021 - 2024		100	<p>“Чадварлаг эмч” арга хэмжээний 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 13 ажлыг гүйцэтгэхээр аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 65,8 хувьтай, орон нутгийн хөгжлийн хөгжлийн сангаас 100,0 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж, 2023 оны 6 сарын байдлаар 65,0 сая төгрөгийг зарцуулаад байна. Хэрэгжилтийн хүрээнд: Дэлхийн эмч нарын эрхийг хамгаалах өдөр, олон улсын сувилагчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эрдэм, шинжилгээний хурал, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж, шалгарсан эмч, сувилагчийг 10,0 сая төгрөгөөр урамшуулсан. Улиастай сумын Дөрвөн-Оноо, Биндэргарав өрхийн эмнэлгүүдэд нярайн шарлалт хэмжих аппаратыг 7,0 сая төгрөгөөр нийлүүлж, алслагдсан багийн иргэдэд</p>	70%
----	---	---	-------------	--	-----	---	-----

34	2.1.5. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.1.5.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, журмыг иргэдэд сурталчилна	2021 - 2024		50	Танхимыг сургалтыг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан 2022 оны ЭМДҮЗ-ийн 01, 05, 11 тогтоолоор 8 удаагийн сургалт зохион байгуулж, 152 эмч мэргэжилтэн хамрагдсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл өгч ажиллаж байна. Улиастай зах, Оргил худалдааны төв, Баруун бүсийн худалдааны төвийн бизнес эрхлэгч 100 гаруй иргэнд үйлчилсэн. Цахим сургалтыг 4 удаа зохион байгуулж, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЭМД-ын ач холбогдол, ЭМС-ын шинэчлэл, 2022 оны ЭМДҮЗ-ийн 01, 02, 05, 06 дүгээр тогтоолоор мэдээлэл өгч 128 ажилтан хамрагдсан. Эмийн сангийн эрхлэгч нарт цахим сургалт 2 удаа зохион байгуулж 35 албан хаагчдад мэдээлэл хүргэсэн байна.	100%
35		2.1.5.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг чадавхжуулна	2021 - 2024		1	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргатай аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээг байгуулан хэрэгжилтийг хангаж байна. Аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэд 4 өрөө байраар хангаж Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг бие даасан байраар хангасан. Тус хэлтэс 3 албан хаагчийн орон тоотой үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%

36	2.2.1. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ.	2.2.1.1. Спортын холбоо, магадлан итгэмжлэгдсэн клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжинэ	2021 - 2024		10	“Сар шинийн харваа 2023” үйл ажиллагаанд 2.8 сая, Даян мэргэн арга хэмжээнд 15.0 сая, аймгийн үндэсний харвааны цол хүртсэн харваачдад 962 мянга, аймгийн Дартсны холбоонд 2.0 сая, аймгийн Хөл бөмбөгийн холбоонд 4.2 сая, Цогтфитнесс клубт 1.0 сая, Берлин 2023 дэлхийн зуны тусгай олимпын волейболын төрөлд оролцох тамирчдад 7.0 сая, Самбо бөхийн азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогч Бямбадоржид 1.5 сая, аймгийн Марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад 1.0 сая, Хүүхдийн спортын VII наадамд оролцогч тамирчдад дэмжлэг 10.0 сая 2023 оны 6 дугаар сарын байдлаар нийтдээ 45,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100%
37		2.2.1.2. Зарим суманд биеийн тамирын арга зүйчийг орон тоогоор ажиллуулна	2021 - 2024		8	Баянтэс суманд үндсэн орон тоогоор 1, Их-уул, Цэцэн-Уул, Тосонцэнгэл сумдад арга зүйчийг хавсран гүйцэтгэж байгаа 3, нийт 5 суманд орон тооны арга зүйч ажиллаж байна.	70%

38		2.2.1.3. "Хөдөлгөөн – Эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021 - 2024		70%	2023 онд Биеийн тамир, спортын газрын төсөвт нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 30.0 сая төгрөг батлагдснаас 17.0 сая төгрөг зарцуулсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Нийтийн биеийн тамир, спортод цаг гаргая" 2 сарын аяны хүрээнд нийтийг хамарсан биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, дугуйн аялал, бүх нийтийн алхалт, уулын аялал, чийрэгжүүлэлт, фитнес, клубийн үйл ажиллагаа, өглөөний дасгал, гүйлт, шугаман бүжиг, биелгээ гэсэн төрлөөр 50 гаруй үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 24 сумын 60139 хүн хамрагдсан. Аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байгууллага, иргэд аж ахуй нэгж, сумдыг урамшуулж 5.0 сая төгрөг зарцуулсан. Хөдөлгөөн-Эрүүл мэнд арга хэмжээний зарим үйл хэрэгсэл Амьс	100%
----	--	--	-------------	--	-----	---	------

39	2.2.2. Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ.	2.2.2.1. Үндэсний спортыг хөгжүүлж, улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулна	2021 - 2024		1	Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээнийг Завхан аймагт зохион байгуулж, тус үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 3,500,000 (гурван сая таван зуу мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тэмцээнд Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн 120 тамирчин оролцож, аймгийн эрэгтэй, эмэгтэй баг тамирчид 1 болон 3 дугаар байранд шалгарч Баянхонгор аймагт зохион байгуулагдах хүүхдийн спортын шигшээ тэмцээнд оролцох эрх авсан байна. Завхан аймгийн Алдархаан сумын уугуул, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Пүрэвийн Жигжидсүрэнгийн нэрэмжит "Ахмад шатарчид"-ын улсын аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 24-25 ны өдрүүдэд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2023 оны 15 дугаар	70%
40		2.2.2.2. Спортын шүүгч, дасгалжуулагчийг бэлтгэж, хүний нөөцийг бэхжүүлнэ	2021 - 2024		50	Монголын волейболын холбооноос 2023 оны 2 сарын 23-28 нд Ховд аймгийн волейболын шүүгчийн сургалтыг зохион байгуулж аймгаас биеийн тамирын багш нарыг хамруулан Волейболын нэгдүгээр зэргийн шүүгчээр Тосонцэнгэл-1, Улиастай-2, Түдэвтэй-1 нийт 4 багшийг бэлдсэн байна. 2023 оны 05 сарын 19-21 нд Сант суманд үндэсний бөхийн гарын даа бэлтгэх сургалтыг зохион байгуулж, үндэсний бөхийн 3 шүүгч бэлдсэн.	100%

41		2.2.2.3. Аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ баг"-ийг байгуулна	2021 - 2024		9	Аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ" баг жүдо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг, үндэсний сур, ширээний теннис, цанын спорт гэсэн 8 төрлөөр байгуулагдсан. 2023 оны Монгол Улсын аварга шалгаруулах чөлөөт бөхийн U15 ангиллын тэмцээнээс 3 хүрэл медаль хүртэж охидын багийн дүнгээр 3-р байр, Самбо бөхийн өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 9 медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр, U-15 насны волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд охид тэргүүн байр, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнээс хөвгүүд мөнгөн медаль хүртсэн, нийт өсвөрийн шигшээ багийн тамирчид 5 алтан медаль, 3 мөнгөн медаль, 7 хүрэл нийт 41 медаль хүртсэн.	100%
42		2.2.2.4. Биеийн тамир, спортын байгууллагыг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		10	Даян мэргэн арга хэмжээний хүрээнд ЕБ-ын 21 сургуулийг шагайн харвааны иж бүрэн зурхайгаар хангасан. Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төвд сагсан бөмбөгийн шит авахад зориулж аймгийн Засаг даргын нөөц сангаас 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн	100%
43	2.2.3. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна.	2.2.3.1. Сургууль түшиглэсэн бялдаржуулах төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		8	2022 онд Орон нутгийн сангийн 5,0 сая төгрөгийн дэмжлэгээр Улиастай сумын ЕБ-ын 3-р сургуулийг бялдаржуулах төвийн тоног төхөөрөмжөөр хангасан.	100%

44	2.2.4. Иргэдэд үйлчлэх нийтийн спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.2.4.1. Нийтийн биеийн тамир, соёл амралтын хүрээлэнг өргөжүүлнэ	2021 - 2024		25	<p>Аймгийн сум бүрт хүүхдийн тоглоомын талбай, Улиастай сумын 6 багийн нутаг дэвсгэрт хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбайг байгуулан (60) хүүхэд тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх орчин бүрдсэн. Улиастай сумын Богдын гол багт "Соёл амралтын хүрээлэн" -нд сагс, волейбол, хөл бөмбөгийн талбай, дугуйн төрөл, дасгал хөдөлгөөн хийх талбай зэрэг орчныг бүрдүүлж өдөртөө 100 орчим хүүхдүүд тоглож байна. 2023 онд Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, иргэд нийтээрээ агаар, салхинд байх ногоон орчныг бүрдүүлсэн "Гэрэлт гудамж" -ийг Улиастай сум ХС-ын 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн. Улиастай сум хариуцан зохион байгуулж худалдаа үйлчилгээний цэгүүдийг байршуулсан байна.</p>	100%
----	---	---	-------------	--	----	---	------

45	2.2.5. Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ.	2.2.5.1. Эрүүл, хооллолт, фитнес клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжинэ	2021 - 2024		12	"Сар шинийн харваа -2023" үйл ажиллагаанд 2.8 сая, Даян мэргэн арга хэмжээнд 15.0 сая, аймгийн үндэсний харвааны цол хүртсэн харваачдад 962 мянга, аймгийн Дартсны холбоонд 2.0 сая, аймгийн Хөл бөмбөгийн холбоонд 4.2 сая, Цогтфитнесс клубт 1.0 сая, Берлин 2023 дэлхийн зуны тусгай олимпын волейболын төрөлд оролцох тамирчдад 7.0 сая, Самбо бөхийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогч Бямбадоржид 1.5 сая, аймгийн Марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулахад 1.0 сая, Хүүхдийн спортын VII наадамд оролцогч тамирчдад 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. 2023 оны 6 дугаар сарын байдлаар 8 чиглэлээр 10 үйл ажиллагаанд нийт 45.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100%
46	2.2.6. Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт сувиллын газрын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.2.6.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлгөөн заслын кабинет, талбайг байгуулна	2021 - 2024		400	"Хөдөлгөөн -Эрүүл мэнд" арга хэмжээ зорилтын хүрээнд 2022 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган орон нутгийн хөгжлийн сангаас 8,0 сая төгрөгийн дэмжлэгтэй хэрэгжсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр 2023 онд Улмажлалт нөхөн сэргээх тасаг сэргээн засах үйлчилгээг 609 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 89 архаг суурь өвчтэй иргэнд тус тус хүргэсэн байна.	100%

47	2.2.7. Бие бялдын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	2.2.7.1. Аймгийн хэмжээнд бие бялдын түвшин тогтоох сорилыг бүх шатанд зохион байгуулна	2021 - 2024		20%	2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 5 дугаар сарын 1 хооронд зохион байгуулагдсан бие бялдын түвшин тогтоох сорил арга хэмжээний хүрээнд аймгийн төрийн албан хаагчдыг хамрууллаа. Нийт 15-64 насны 354 иргэн хамрагдаж байгууллагын өөрийн хөрөнгөөс 1.0 сая төгрөгийн төсөв зарцуулагдсан.	100%
